



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/147

Сүхбаатар

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 222 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

-Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

-Аймгийн Татварын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн байгалийн нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн

-“Бороо гоулд” ХХК-ий төлөөлөл

-“Болд төмөр Ерөө гол” ХХК-ий төлөөлөл

-“Хатан Ерөө гол” ТББ-ын тэргүүн

2.Олборлох үйлдвэрлэлийн тайланг жил бүрийн 4-р сарын 15-нд Татварын ерөнхий газарт хүргүүлэн, иргэдэд нээлттэй мэдээлж, хяналт тавьж ажиллахыг дэд зөвлөлийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч /Н.Батдорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ